



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 1/73

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг газрын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 438 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигч Иргэний нисэхийн үндэсний төв Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Баянхонгор аймаг дахь салбарын эзэмшилд байгаа Агаарын тээврийн барилга байгууламж, төхөөрөмжийн талбай, Нисэх, буух зурвас бүхий 2 нэгж талбарыг Иргэний нисэхийн үндэсний төв ХХК (ТБОНӨО)-д шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхээ шилжүүлж байгаа болон шилжүүлэн авч байгаа байгууллагуудын үндсэн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Эзэмшил газрын өөрчлөлтийг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4.Эзэмшил газраа зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч байгууллагад үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

6.Энэ захирамж гарсантай холбогдуулан 1998 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр бичигдсэн 0420-0018 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010167

Аймгийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 02-ны
 өдрийн 173 Дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Газар эзэмших эрхээ шилжүүлж буй					Газар эзэмших эрх шилжүүлэн авч буй иргэний мэдээлэл								
№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Нэгж талбарын хаяг	Газрын хэмжээ м2	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Газрын эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ м2	Нэгж талбарын хаяг	Газар ашиглалтын зориулалт	Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа
1	Иргэний нисэхийн үндэсний төв Төрийн өмчит ААТҮГазрын Баянхонгор аймаг дахь салбар	6577539	6409009833	Баянхонгор сум, Есөнбулаг 9-р баг, Нисэхийн гудамж-4, 409 тоот	13019	Иргэний нисэхийн үндэсний төв ХХК /ТБОНӨ/	7144857	Эзэмших	6409009833	13019	Баянхонгор сум, Есөнбулаг 9-р баг, Нисэхийн гудамж-4, 409 тоот	Агаарын тээврийн барилга, байгууламж, төхөөрөмжийн талбай	10 жил
2			6409009834	Баянхонгор сум, Есөнбулаг 9-р баг, Нисэхийн гудамж-4, 409а тоот	1031348				6409009834	1031348	Баянхонгор сум, Есөнбулаг 9-р баг, Нисэхийн гудамж-4, 409а тоот	Нисэх, буух зурвас	